

**Zitterpappel / Aspe**

Герман нэршил

**Улиангар**Монгол нэршил  
Монголд 1 зүйл**Populus tremula**

Латин нэршил

**Тодорхойлолт:**

Улиангар нь голын сав хөндий болон уулын чулуурхаг энгэрээр ургана. Зулзаган улиангарууд нэлээд шигүү байрласан байдаг. Модлогийг нь бараг ашигладаггүй. Навч нь үл мэдэг төдий салхинд ч чичигнэн хөдөлдөг. Хоёр гэртэй, боловсорсон үр нь хөвөн ноолууртай болдог.

Улиангарыг суулгацаар биш, үндэсний нахиагаар үржүүлдэг. Үрийн соёлолт муу.

**Мэдээлэл:** 60 орчим насалж 15 метр орчим өндөр ургана. Цайвар холтостой тул чимэглэлийн ач холбогдолтой. Барилга байшинтай хэт ойр тарьж болохгүй!

**Грайфсвалдын Их Сургуулийн гербари** [http://greif.uni-greifswald.de/floragreif/?flora\\_search=Taxon&taxon\\_id=2100](http://greif.uni-greifswald.de/floragreif/?flora_search=Taxon&taxon_id=2100)

Дэлгэрэнгүй мэдээлэл, тархалтын зураг болон бусад зургуудтай дээрх холбоосоор орж танилцана уу.